



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан
итгэмжлэлийн тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8¹ дахь заалтыг үндэслэн **ТУШААХ**
нь:

- “Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэлийн журам” –
ыг нэгдүгээр, “Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх
шинжээч ажиллуулах журам” -ыг хоёрдугаар, “Магадлан шинжлэх үйлчилгээний
төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг” -ийг гуравдугаар, биеийн тамир,
спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуурыг
дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.
- Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх үйл
ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч
агентлаг-Биеийн тамир, спортын газар/Ч.Наанбаатар/-т үүрэг болгосугай.
- Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх үйл
ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тушаалын хэрэгжилтэд
хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 234
тоот тушаалыг хүчингүй болгосугай.



С. ЛАМБАА

032694

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10
дүгээр сарын 15 -ний өдрийн 368
тоот тушаалын 1 дүгээр хавсралт

**“БИЕИЙН ТАМИР, СПОРТ, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ЖУРАМ”**

Нэг. Нийтлэг зүйл

1. Энэхүү журмын зорилго нь биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн төрийн ба төрийн бус байгууллага, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн өмчийн бүх хэлбэрийн байгууллагын үйл ажиллагааг ангилан зэрэглэж тэдний ажил, үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гарган магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэл нь /цаашид “магадлан итгэмжлэл” гээнэ/ тухайн байгууллагын биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй шуурхай үзүүлэх чадамжийг төрөөс хүлээн зөвшөөрсөний илэрхийлэл болно.
3. Магадлан итгэмжлэл нь уг байгууллагын өрсөлдөх чадварын нотолгоо, төрийн дэмжлэг авах баталгаа, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх итгэлцүүр болно.
4. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд “Биеийн тамир, спортын тухай хууль”, болон холбогдох хууль тогтоомж, журам, стандарт болон бусад холбогдох эрхийн актыг дагаж мөрдөнө.
5. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагдаж, нээлттэй, ил тод, бусдын нөлөөнд үл автах, шударга байх зарчимд тулгуурлана.
6. Магадлан итгэмжлэх явуулах биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага нь магадлан итгэмжлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж дараах үүргийг хүлээнэ:
 - 6.1 Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн гаргасан нэгдсэн дүгнэлтэд санал өгөх;
 - 6.2 Шинжээчээр ажиллах хүсэлт гаргасан, шаардлага хангасан хүмүүсийг сонгон шалгаруулах;
 - 6.3 Шинжээчдийн шалгуур үзүүлэлтийн дагуу ажиллах журам үнэлгээ өгөх аргачлалыг боловсруулах;
 - 6.4 Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны тайлан, мэдээллийг хэлэлцэн үнэлгээ өгөх;
 - 6.5 Магадлан итгэмжлэлтэй холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, давтан магадлан шинжилгээ хийх шинжээчдийн шинэ баг томилох;

- 6.6 Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа болон төсөв санхүүгийн зарцуулалтад 6 сар тутам хяналт тавих;
- 6.7 Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцогч байгууллага, хүмүүст зөвлөмж, үүрэг өгөх, шаардлага тавих, шагнаж урамшуулах;
- 6.8 Ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гишүүнээр элсэх.
7. Улсын бүртгэлд бүртгүүлсэн 2 ба түүнээс дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргаж болно.
8. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллага нь үйлчилгээний төлбөр төлнө.
9. Магадлан итгэмжлэлийн батламжийг магадлан итгэмжлэл хариуцсан биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар олгоно.
10. Магадлан итгэмжлэх байгууллага нь магадлан итгэмжлэгдсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагын холбогдолтой мэдээллийг агуулсан мэдээний сан үүсгэн, тогтмол шинэчилж ажиллана.

Хоёр. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа

11. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэлийг үйл ажиллагааны болон үйлчилгээний гэсэн 2 төрлөөр хийнэ.

Үйл ажиллагааны магадлан итгэмжлэл гэж биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилготой нийгэмд болон гишүүддээ үйлчилдэг спортын холбоод, биеийн тамир, спортын төрийн ба төрийн бус байгууллагад тавих хөндлөнгийн мэргэжлийн шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргахыг хэлнэ.

Үйлчилгээний магадлан итгэмжлэл гэж спортын төрөл, дасгал, идэвхитэй хөдөлгөөнөөр дамжуулан чийрэгжүүлэх, бялдаржуулах ажил, аж ахуйн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйлчилгээний чанарт тавих хөндлөнгийн мэргэжлийн шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргахыг хэлнэ.

Үйл ажиллагааны магадлан итгэмжлэл: Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллага үйл ажиллагааны магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргахдаа дараахь материалыг бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ:

- 11.1 магадлан итгэмжлэх байгууллагаас батлагдсан маягтын дагуу гаргасан магадлан итгэмжлэлд хамрагдах тухай өргөдөл;
- 11.2 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 11.3 байгууллагыг анх үүсгэн байгуулахад бүрдүүлсэн баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 11.4 байгууллагын үйл ажиллагааг Монголын үндэсний олимпийн хороо, Монголын паралимпийн хороо, Монголын сонсголын бэрхшээлтэй тамирчдын үндэсний хороодоос тус тусын чиглэлээр дэмжсэн албан бичиг;

- 11.5 байгууллага үйл ажиллагааныхаа чиглэлээр Олон улсын холбоог Монгол улсад төлөөлөх албан ёсны гишүүн болохыг баталгаажуулсан баримт бичиг нотариатаар гэрчлүүлсэн монгол орчуулгын хамт;
- 11.6 Олон улсын холбоонд төлсөн татварын баримт сүүлийн 2 жилээр;
- 11.7 Монгол улсыг төлөөлж олон улсын тэмцээнд оролцох, шигшээ баг бүрдүүлэх тухай байгууллагын журам;
- 11.8 магадлан итгэмжлэх шалгуурын дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ, үнэлгээ;
- 11.9 байгууллагын сүүлийн 2 жилийн үйл ажиллагааны тайлан, чанарын үзүүлэлтийн хамт;
- 11.10 магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт.
12. **Үйлчилгээний магадлан итгэмжлэл:** Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллага үйлчилгээний магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргахдаа дараахь материалыг бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ:
- 12.1 магадлан итгэмжлэх байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан магадлан итгэмжлэлд хамрагдах өргөдөл;
- 12.2 Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон ажлын байрны дүгнэлт;
- 12.3 магадлан итгэмжлэх шалгуурын дагуу өөрийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ, үнэлгээ;
- 12.4 байгууллагын сүүлийн 2 жилийн үйл ажиллагааны тайлан, чанарын үзүүлэлтийн хамт;
- 12.5 биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн сургалтын батлагдсан хөтөлбөр;
- 12.6 тухайн үйлчилгээний төрлөөр магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн холбооны тодорхойлолт;
- 12.7 магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт;
- 12.8 байгууллагын сүүлийн 2 жилийн татвар төлсөн татварын байгууллагын тодорхойлолт.
13. Магадлан итгэмжлэх байгууллага нь магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргасан байгууллагад магадлан шинжилгээ явуулах товыг мэдэгдэж, шинжээчдийн багийг томилон ажиллуулж, 30 хоногийн дотор магадлан итгэмжлэл олгох эсэхийг шийдвэрлэнэ.
14. Магадлан шинжилгээг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаас эрх олгосон шинжээч нар гүйцэтгэх ба магадлан итгэмжлэл хариуцсан биеийн тамир, спортын төрийн захирагааны байгууллага шинжээчидтэй гэрээ байгуулж ажиллана.
15. Шинжээчид хүсэлт гаргасан байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний зэрэглэлээс хамааран магадлан шинжилгээ, дүгнэлтийг шинжээчид ажлын 1-3 хоногт газар дээр нь хийж дүнг тухайн байгууллагын удирдлага, хамт олонд урьдчилсан байдлаар танилцуулна.
16. Шинжээчид магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг 80 ба түүнээс дээш хувь хангасан байгууллагын дүнг магадлан шинжилгээг гүйцэтгэж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан магадлан итгэмжлэх

байгууллагад ирүүлнэ. Шинжээчдийн багийн дүгнэлтийг үндэслэн магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй байгууллагад магадлан итгэмжлэх явуулах биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагаас тэнцээгүй болохыг албан бичгээр мэдэгдэнэ.

17. Магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргасан байгууллага магадлан итгэмжлэх шалгуурыг хангаагүй тохиолдолд шалгуурыг хангасан гэж үзсэнийхээ дараа дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж болно.
18. Үйл ажиллагааны магадлан итгэмжлэлийн батламжийг шалгуур үзүүлэлтийг 70-аас дээш хувь хангасан бол 4 жилийн хугацаатай олгоно.
19. Үйлчилгээний магадлан итгэмжлэлийн батламжийг шалгуур үзүүлэлтийг хангасан хувийг харгалзан 80-84 хувьд 3 дугаар зэрэглэлийн 2 жилийн, 85-94 хувьд 2 дугаар зэрэглэлийн 3 жилийн, 95-100 хувьд 1 дүгээр зэрэглэлийн 4 жилийн хугацаагаар тус тус олгоно.
20. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад батлагдсан загварын дагуу батламж олгож, алдаршуулах хаяг хэрэглүүлж болно.
21. Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан байгууллага дахин магадлан итгэмжлүүлэхдээ энэ журмын 1 дүгээр хавсралтын 12, 13-т заасны дагуу хүсэлтээ гаргана.
22. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт магадлан итгэмжлэх байгууллага хяналт-шинжилгээ хийнэ.

Гурав. Магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

23. Магадлан итгэмжлэлийн хүчин төгөлдөр үйлчлэлийг дараах нөхцөлд түр түдгэлзүүлнэ:
 - 23.1 магадлан итгэмжлэгдсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагын үйлчилгээний чанар, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөнийг мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтоосон,
24. Магадлан итгэмжлэлийн хүчин төгөлдөр үйлчлэлийг тодорхой хугацаагаар зогсоох нь түүний үйлчлэх хугацааг нөхөн олгох, сунгах нөхцөл болохгүй.
25. Магадлан итгэмжлэлийн хүчин төгөлдөр үйлчлэлийг түр түдгэлзүүлэх шийдвэрт зөрчил, дутагдлыг арилгах хугацааг 3 сараас илүүгүй байхаар тогтооно.
26. Магадлан итгэмжлэлийг дор дурдсан нөхцөлд хүчингүй болгоно:
 - 26.1 хүний эрүүл мэнд хохирсон, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйлчилгээ явуулах хөтөлбөр, стандартыг зөрчсөнийг мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтоосон;
 - 26.2 магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтоосон зөрчил, дутагдлыг арилгаагүй бол;
 - 26.3 магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан;
 - 26.4 хуурамч бичиг баримт бүрдүүлж магадлан итгэмжлэл авсан нь тогтоогдсон;
 - 26.5 магадлан итгэмжлэгдсэн байгууллага татан буугдсан;

- 26.6 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа эрхлээгүй.
27. Магадлан итгэмжлэл авсан, итгэмжлэлийг нь хүчингүй болгосон байгууллагыг бүртгэж, нийтэд зарлана.
28. Энэ журмын 26.3, 26.5-д зааснаас бусад тохиолдолд магадлан итгэмжлэл нь хүчингүй болсон биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллага нь илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгасны дараа шинээр хүсэлт гаргана.

Дөрөв. Маргааныг шийдвэрлэх

29. Магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргасан байгууллага шинжээчдийн дүгнэлттэй санал нийлэхгүй бол Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргаж шинжээчдийн шинэ баг томилуулан давтан магадлан шинжилгээ хийлгэж болох ба журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан зардлын жишгийн 3, 4-т заасан зардлыг хүсэлт тавьсан байгууллага гаргана.
30. Магадлан итгэмжлэлтэй холбоотой маргааныг эвийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10 дүгээр сарын 15-ний өдрийн 263 тоот тушаалын 2 дугаар хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТ, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрхийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжилтнийг магадлан итгэмжлэлийн шинжээч (цаашид шинжээч гэх) гэнэ.

Хоёр. Шинжээч сонгон шалгаруулах

- 2.1. Шинжээчийг 2 жил тутамд нийтэд нээлттэй зарлаж сонгон шалгаруулна.
- 2.2. Шинжээчийн шалгаруулалтад мэргэжлийн дүгнэлт гаргах эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн байгууллагын ажиллагсад, хувь хүн нэрээ дэвшүүлнэ. Шинжээч нь дараахь шаардлагыг хангасан байна:
 - 2.2.1. Мэргэжлийн, эрдмийн зэрэг цолтой;
 - 2.2.2. Байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай, дадлага туршлагатай, мэргэшсэн;
 - 2.2.3. Тухайн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байсан туршлага бүхий;
 - 2.2.4. Мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан;
 - 2.2.5. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй;
- 2.3. Шинжээчээр ажиллах хүсэлт гаргахдаа дараахь материалыг бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ:
 - 2.3.1. өргөдөл;
 - 2.3.2. биеийн байцаалт (төрийн албан хаагчийн 1-р маягтаар);
 - 2.3.3. иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 2.3.4. боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар;
 - 2.3.5. шинжээчээр ажиллахыг дэмжсэн байгууллага, хамтран ажиллаж байсан 2 хүний тодорхойлолт;
 - 2.3.6. 2 хувь цээж зураг;
 - 2.3.7. Цагдаагийн байгууллагын ял шийтгэлгүйг нотолсон тодорхойлолт.
- 2.4. Шалгаруулалтанд тэнцсэн хүмүүст шинжээчийн эрхийг магадлан итгэмжлэх байгууллагын саналыг үндэслэн биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 4 жилийн хугацаагаар олгоно.

Гурав. Шинжээчийг томилон ажиллуулах

- 3.1. Магадлан итгэмжлэх байгууллага нь шинжээчид нэр дэвшиүүлсэн байгууллага, шинжээчтэй гэрээ байгуулж ажиллуулна.
- 3.2. Магадлан итгэмжлэх байгууллагаас шинжээчийг магадлан шинжлэх арга зүйн сургалтанд хамруулна.
- 3.3. Магадлан итгэмжлэх байгууллага биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагад магадлан шинжилгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж шинжээчдэд 2 долоо хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 3.4. Шинжээч нь магадлан итгэмжлэх байгууллагатай эдийн засгийн харилцаа холбоогүй, удирдлагын багийн гишүүдтэй төрөл садан биш байна.
- 3.5. Шинжээчид байгууллагын магадлан шинжилгээнд оролцсон хугацаа, ажлын үр дүнг нь харгалзан магадлан итгэмжлэх байгууллага ажлын хөлс олгоно.
- 3.6. Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар томилно. Үүнд:
 - 3.6.1. Үйл ажиллагааны магадлан итгэмжлэл хийх шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд санхүү эдийн засаг, хууль эрх зүй, боловсрол, биеийн тамир, спорт, удирдлагын менежментийн мэргэжилтэн шинжээчид ажиллана;
 - 3.6.2. Үйлчилгээний магадлан итгэмжлэл хийх шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд эрүүл мэнд, стандартчилал, хэмжил зүй, барилга, эрүүл ахуй, биеийн тамир, спорт, боловсрол, хууль эрх зүй, санхүү эдийн засаг, маркетинг-менежментийн мэргэжилтэн шинжээчид ажиллана.

Дөрөв. Шинжээчийн эрхийг сунгах, хүчингүй болгох


- 4.1. Шинжээч нь магадлан шинжилгээг мэргэшлийн өндөр түвшинд хийж мэргэжлийн зөрчил гаргаагүй бол магадлан итгэмжлэх байгууллага шинжээчийн эрхийг дахин 4 жилийн хугацаагаар сунгана.
- 4.2. Дөрвөн жил тутам шинжээчдийн багийн гуравны нэг шинэчлэгдэж байх ба шинжээчээр 8 жил ажилласан мэргэжилтэн 4 жил завсарласны дараа дахин шинжээчээр ажиллах хүсэлт гаргаж болно.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10
дүгээр сарын 15 -ний өдрийн 163 тоот
тушаалын 3 дугаар хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТ, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГЫГ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ,
ХОЛБОГДОХ
ЗАРДЛЫН ЖИШИГ**

№	Үйлчилгээний нэр	Зардлын хэмжээ (төгрөгөөр)
1	Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг магадлан шинжлэх үйлчилгээний төлбөр: 1. Анх удаа үйлчилгээний магадлан итгэмжлэл хийлгэх хүсэлт гаргасан байгууллага 2. Анх удаа үйл ажиллагааны магадлан итгэмжлэл хийлгэх хүсэлт гаргасан байгууллага 3. Зэрэглэлээ ахиулах байгууллага 4. Магадлан итгэмжлэлийн хугацаа сунгуулах байгууллага	300,000 400,000 500,000 600,000
2	Магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны төлбөр (мэдээлэл, зөвлөгөө авах, сургалтанд хамрагдах) Сургалт хийж, зөвлөгөө өгсөн мэргэжилтний ажлын хөлс (нэг байгууллагад)	100,000 30,000
3	Шинжээчийн ажлын хөлс (нэг биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагад) <ul style="list-style-type: none"> • Шинжээч • Шинжээчийн багийн ахлагч 	40,000 65,000
4	Шинжээчийн шинжилгээ, үнэлгээний дүнд санал, дүгнэлт гаргах (нэг биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллагад)	50,000

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10
дугаар сарын 25-ний өдрийн 362 тоот
тушаалын 4 дугаар хавсралт



**БИЕЙН ТАМИР, СПОРТ, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГЫГ
МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

Нийтлэг шалгуур

№	Шалгуур	Үзүүлэлт	Үйл ажиллагааны	Үйлчилгээний магадлан
			Магадлан итгэмжлэлд авч болох дээд оноо 50	итгэмжлэлд авч болох дээд оноо 35
			Үнэлгээ	Оноо
			Үнэлгээ	Оноо
1.	Хууль эрх зүйн чадамж	1.1. Холбогдох хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжиilt, тайлан бүртгэлийн этгээдийн улсын 1.2. Хуулийн гэрчилгээ, шаардлагатай бол мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл. 1.3. Тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсын бүрдэл, харилцах данс 1.4. Байгууллагын батлагдсан дурэм,	Нийт = 20 95 - 100 = 20 88 - 94 = 17 80 - 87 = 14 70 - 79 = 11 0 - 69 = 8	30 10 10 10 10
			Үнэлгээ	Оноо
				30
				Нийт = 10 95 - 100 = 10 88 - 94 = 8 80 - 87 = 6 70 - 79 = 4 0 - 69 = 2

		журам, бүтэц орон тоо, стратеги /бизнес/ уйл ажиллагааны жилийн төлөвлөгөө	20		20	
1.5.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	2.1. Батлагдсан орон тооны дагуу бураэн бурэлдэхүүнээр ажиллаж байгаа эсэх	10		20	
2.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхи	2.2. Удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, ажлын байрны тодорхойлолт 2.3. Ажилтан албан, хаагчдын мэргэжил, боловсролын гэрчилгээ, ур чадварын үнэлгээ, 2.4. Мэргэжил дээшлүүлсэн байдал 2.5. Ажилтны нийтмийн хамгаалал, бичиг баримт, хувийн хэргийн бурдэл	20	Нийт = 5 95 - 100 = 5	20	Нийт = 5 95 - 100 = 5
3.	Ажлын байрны нөхцөл, ажиллах орчин	3.1. Мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан ажлын байрны дүгнэлт 3.2. Цагин, урамшуулал, хөдөлмөр хамгааллын нөхцөл, ажилчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	60	Нийт = 5 95 - 100 = 5 88 - 94 = 4 80 - 87 = 3 70 - 79 = 2 0 - 69 = 1	70	Нийт = 5 95 - 100 = 5 88 - 94 = 4 80 - 87 = 3 70 - 79 = 2 0 - 69 = 1
4.	Хөрөнгө санхүү, эдийн засгийн нөөц чадамж	4.1. Тухайн жилд зохиогдох уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах санхүүгийн зардлын төсвийн мэдэгдэл.	30	Нийт = 15 95 - 100 = 15 88 - 94 = 13 80 - 87 = 11	40	Нийт = 10 95 - 100 = 10 88 - 94 = 8 80 - 87 = 6

	4.2. Ул хөдлөх хөрөнгийн үнэлгээ, гэрчилгээ, эргэлтийн хөрөнгийн байдал 4.3. Татвар, Даатгал, хяналтын мэргэжлийн байгууллагын дүгнэлт	40	70 - 79 = 9 0 - 69 = 7	40	70 - 79 = 4 0 - 69 = 2
	5.1. Статистик, буртгэл судалгааны материал, архив, бичиг хэргийн хөтөлбөт	20	Нийт = 5 95 - 100 = 5 88 - 94 = 4	20	Нийт = 5 95 - 100 = 5 88 - 94 = 4
	5.2. Дотоод хяналт, ил тод байдлын хэрэгжилт	20	88 - 94 = 4 80 - 87 = 3	10	88 - 94 = 4 80 - 87 = 3
	5.3. Нийгмийн үүрэг, хариуцлагын хэрэгжилт	20	70 - 79 = 2	30	70 - 79 = 2
5. дотоод ажлын үнэлгээ	5.4. Байгууллагын үйл ажиллагааны тайлан, дүрэм, дотоод журмын биелэлт	40	0 - 69 = 1	40	0 - 69 = 1

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

№	Шалгур	Үзүүлэлт	Авч болох дээд оноо	
			Үнэлгээ	Оноо
1.	Хувь эрх зүй, тогтоол, шийдвэр, бодлогын	4.1 Хөгжлийн хэтийн бодлого, төлөвлөгөө 4.2 Сургалт дасгалжуулалтын олон жилийн шаталсан төлөвлөгөө	40 60	Нийт = 5 95 - 100 = 5 88 - 94 = 4 80 - 87 = 3

	хэрэгжилт					
2.	Үйл ажиллагаа	<p>2.1. Улс, олон улсын чанартай тэмцээн зохион байгуулсан байдал /насны ангиллаар/</p> <p>2.2. Сургалт семинар, хурал, зөвлөгөөнд оролцсон, зохион байгуулсан байдал</p> <p>2.3. Хөрөнгө оруулалт, материалыг баазын хүрэлцээ, хангамж</p> <p>2.4. Хүний нөөцийн хангамж, давтан сургалт, буртгэл судалгаа</p> <p>2.5. Эрдэм шинжилгээний ажил, судалгаа, бүтээл туурвил хийхэд дэмжлэг үзүүлсэн байдал</p>	15	15	Нийт = 15	
3.	Тамирчдын амжилт	<p>3.1. Олимп, дэлхий, тив, олон улсын тэмцээнд оролцсон байдал, үзүүлсэн амжилт /насны ангиллаар/</p> <p>3.2. Рекорд, дээд амжилтыг шинэчилсэн байдал, буртгэл судалгаа /хэмжигдхүүнтэй спортын төрлүүд/</p> <p>3.3. Залуучууд, Насанд хүрэгчдийн үндэсний болон холбооны шигшээ баг байгуулсан байдал</p> <p>3.4. Өсвөр үеийн шигшээ баг байгуулсан аймаг, дүүргийн тоо УАШТ-нд нийспэл, орон нутгийн байгууллагуудын хамрагдсан судалгаа</p> <p>3.5. Спортын зэрэг, цолтой тамирчин, шүүгчдийн тоо, буртгэл судалгаа</p> <p>3.6. Спортын зэрэг, цолтой тамирчин, шүүгчдийн тоо, буртгэл судалгаа</p> <p>3.7. Допингийн шинжилгээнд хамрагдаж байсан байдал</p>	40	5	Нийт = 20	
4.	Хөгжлийн хүрээ	<p>4.1. Олон улсын холбоо, салбар зөвлөлд сонгуультай гишүүний тоо</p> <p>4.2. Олон улсын холбоонд татвар төлөлтийн байдал</p> <p>4.3. Олон улсын шүүгчийн тоо, буртгэл судалгаа</p>	7	5	Нийт = 5	

$$\begin{array}{l} 70 - 79 = 2 \\ 0 - 69 = 1 \end{array}$$

$$\begin{array}{l} 95 - 100 = 15 \\ 88 - 94 = 13 \end{array}$$

$$\begin{array}{l} 80 - 87 = 11 \\ 70 - 79 = 9 \end{array}$$

$$\begin{array}{l} 0 - 69 = 7 \end{array}$$

40

10

10

10

8

7

5

$$\begin{array}{l} 95 - 100 = 5 \\ 88 - 94 = 4 \end{array}$$

$$\begin{array}{l} 80 - 87 = 3 \end{array}$$

		4.4. Монгол хэл дээр гаргасан тэмцээний олон улсын дүрэм	15	70 - 79 = 2 0 - 69 = 1
		4.5. Салбар зөвлөл, холбоод, байгын тогтмол үйл ажиллагаатай клубийн тоо, буртгэл судалгаа	25	
		4.6. Гүнзгийрүүлсэн сургалттай анги, сургуультай эсэх	20	
		5.1. Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, оролцсон байдал	30	Нийт = 5
5.	Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа	5.2. Нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал	30	95 - 100 = 5
		5.3. Мэдээлэл, сургалт, сургалчилгаа хийсэн байдал	20	88 - 94 = 4
		5.4. Тамирчид, дасгалжуулагч, шүүгчийн нийгмийн халамж үйлчилгээ	20	80 - 87 = 3
				70 - 79 = 2 0 - 69 = 1

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуйр	Үзүүлэлт	Авч болох дээд оноо	
			Үнэлгээ	Оноо
1.	Хууль эрх зүйн баримт бичиг	1.1. Стандартын хэрэгжилт, тайллан 1.2. Гэрээ, хэлцэл, санамж бичгүүдийн баталгаат байдал	70 30	Нийт = 10 95 - 100 = 10
2.	Эрүүл ахуй, аюулгүй	2.1. Чийрэгкүүлэх, бялдаржуулах үйлчилгээ. Нийтлэг шаардлага MNS 5538:2005	20	Нийт = 30 95 - 100 = 30

	орчин бүрдүүлсэн	<p>2.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000</p> <p>2.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага. MNS 4996:2000</p> <p>2.4. Агааржуулалтын систем. Ерөнхий шаардлага MNS 0012-4-006:1985</p> <p>2.5. Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5525:2005</p> <p>2.6. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 5390:2004</p> <p>2.7. Цанын бааз, мөсөн гулгуурын талбайн үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандарт. MNS 6000:2009</p> <p>2.8. Эрүүл мэндийн сайдын 2010 оны 49 тоот тушаал “Тамирчдын ажиллах чадварыг хязгаарлагч хүчин зүйлсийг эмийн хэрэглээгээр зохицууллах удирдамж”</p> <p>2.9. “Биийн тамир, спортоор хичээллэгчдэд тавих эмнэлгийн хяналт, үйл ажиллагааны сорилын удирдамж”,</p>	<p>15</p> <p>88 - 94 = 26 80 - 87 = 22 70 - 79 = 18 0 - 69 = 14</p> <p>10</p> <p>10</p> <p>10</p> <p>5</p> <p>5</p> <p>10</p> <p>40</p> <p>20</p> <p>15</p> <p>25</p>	<p>Нийт = 10</p> <p>95 - 100 = 10 88 - 94 = 8 80 - 87 = 6 70 - 79 = 4 0 - 69 = 2</p>
3.	Хүний нөөцийн чадавхи, мэргэжил Дээшлүүлэх ажлын зохион байгуулах	<p>3.1. Биийн тамирийн багш, спортны дасгалжуулагч. MNS 5323-12:2004</p> <p>3.2. Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ үйлчилгээний түгээмэл үйлдлүүд MNS 4621:1998</p> <p>3.3. Туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг ахиулах, дадлагажуулах сургалтад хамруулсан байдал</p> <p>3.4. Ажиллагсдын эрүүл мэнд, хувийн хэргийн бурдүүлэлт, дэлгэрэнгүй судалгаа</p>	<p>40</p> <p>20</p> <p>15</p> <p>25</p>	<p>Нийт = 10</p> <p>95 - 100 = 10 88 - 94 = 8 80 - 87 = 6 70 - 79 = 4 0 - 69 = 2</p>

				Нийт = 5
		4.1. Үйлчилгээний сэтгэл ханамжийн байдал 4.2. Үйлчилгээ үзүүлэх журам бусад лавлагаа мэдээллийг ил тод байрлуулсан байх	20 10	95 - 100 = 5
4.	Үйлчилгээний хүртээмж,	4.3. Санал, хүсэлтийн хайрцаг ажилуулах, түүний шийдвэрлэлт 4.4. Ажилтан, албан хаагчдын ёс зүй, ур чадвар, харилцааны соёл 4.5. Хичээллэгчийн дэлгэрэнгүй бүртгэл, судалгаа	10 15 10	88 - 94 = 4 80 - 87 = 3
		4.6. Тухайн үйлчилгээгүйд зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөр 4.7. Мэдээлэл, сургалт, сурталчилгаа, зөвлөгөө хийсэн байдал 4.8. Эрдэм шинжилгээ, судалгаа хийсэн, үнэлгээ, статистик дүн мэдээ гаргасан байдал	20 8 7	70 - 79 = 2 0 - 69 = 1
				Нийт = 10
5.	Санхүү	5.1. Төлбөр, хураамжийн хэлбэр байдал 5.2. Батлагдсан үйлчилгээний төлбөр хураамжийн тариф 5.3. Санхүүгийн тайлан	30 40	95 - 100 = 10 88 - 94 = 9 80 - 87 = 7
				70 - 79 = 6 0 - 69 = 3